



**Доктор, профессор ДЭЛЭГИЙН БАТ-ЭРДЭНЭ  
(1943-2012)**

Монголын нэрт геологич, эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, шинжлэх ухааны доктор, профессор Дэлэгийн Бат-Эрдэнэ хүнд өвчны улмаас таалал төгссөн нь Монголын геологи, нүүрсний салбарын судалгаанд хүнд гарз боллоо.

Д.Бат-Эрдэнэ нь 1943 онд Ховд аймгийн Буянт суманд төрж, 1962 онд Ховд хотын 10 жилийн сургууль, 1967 онд хуучнаар ЗХУ-ын ПДС-ийг уурхайн инженер-геологич мэргэжлээр төгсөж, 1976 онд докторын, 1992 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Тэрээр дээд сургууль төгссөнөөсөө хойш 1968-1997 оны хооронд Чойр болон Улаанбаатарын Геологийн удирдах газарт ерөнхий инженер, ерөнхий геологич, ТЭХҮГ Яаманд мэргэжилтэн, Сайд нарын зөвлөлийн Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн АЭСК-ын хариуцлагатай нарийн бичгийн дарга, хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч, ГУУҮШ Институтада эрдэм шинжилгээний ахлах ажилтан, секторын эрхлэгч, “Монгол газрын тос” компанийн ерөнхий геологчоор тус тус ажиллаж байв.

Д.Бат-Эрдэнэ нь 1994-2005 онд МУИС-ийн Геологийн салбарт багшлаж, 1998 онд дэд профессор, 2004 онд профессор цол хүртсэн байна. Түүний боловсролын салбарт ажилласан 10 жилд шатах ашигт малтмалын чиглэлээр 200 орчим залуу мэргэжилтэн бэлтгэгджээ.

Тэрээр бүхий л авьяас чадвар, эрдэм мэдлэг, ухамсарт амьдралаа Монголын шатах ашигт малтмалын геологийн салбарт зориулсан бөгөөд энэхүү хугацааных нь гуравны хоёр нь эрдэм шинжилгээ, боловсролын салбартай холбоотой байдаг. Д.Бат-Эрдэнэ эрдэм шинжилгээний 170 гаруй бүтээл, 10 ном, 10 гаруй тайлан, 8 зөвлөмж боловсруулж, хэд хэдэн атлас, нэвтэрхий толийн зохиогч, редактороор ажилласан нэрт эрдэмтэн, геологич, сурган хүмүүжүүлэгч байлаа.

Доктор Б.Бат-Эрдэнэ нь Монгол Улсын нүүрс, шатдаг занарын байршлын зүй тогтолын судалгаагаар анхны том эрдэм шинжилгээний ажлыг хийж, олон арван жилийн турш ашиглаж байгаа манай улсын нүүрсний ордууд, мөн стратегийн ач холбогдолтой Таван толгой, Тэвшийн говь, Өвдөг худаг зэрэг томоохон ордуудыг эрэх, хайх нөөц баялгийг тогтоох ажилд биечлэн оролцож, зөвлөж байсан нь Монгол улсын хөгжилд түүний оруулсан дорвитой хувь нэмэр юм.

Доктор, профессор Д.Бат-Эрдэнэ багш таны ажил хэрэгч, зарчимч, шударга төлөв даруу, нөхөрсөг, хүнлэг зан чанар, гэгээн дүр тань бид бүхний болон олон арван шавь нарынх нь зүрх сэтгэлд үүрд мөнхрөн үлдэх болно.

МУИС-ийн Геологийн тэнхим, Ашигт малтмалын тэнхим  
МУИС-ийн Газарзүй-Геологийн сургуулийн захиргаа  
МУИС-ийн захиргаа

